



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар /Барилга хот байгуулалтын сайдын багц/ санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан 4 нэрийн, нийт 356,900,000.00 (гурван зуун тавин зургаан сая есөн зуун мянга) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Говь-Алтай аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Төмөрхүү, Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, байнгын ашиглалтад хүлээн авч, эзэмшигчийг тогтоож, бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;


2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

~~ДАРГА~~

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

**132000092**  
1-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2025 оны 01 дүгээр сарын 09 өдрийн  
 01 дүгээр тогтоолын хавсралт



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙДЫН БАГЦ)-ААР  
 БИЙ БОЛСОН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгө оруулалтын ажлын төсөл арга хэмжээний нэр, байршил	Бүртгэлт тусгах хөрөнгийн нэр, хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Бүртгэлд тусгах хөрөнгийн дүн (төгрөг)		Улсын комиссын акт
					Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	
1	Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц /Говь-Алтай, Цээл сум/	Гадна дулаан, цэвэр усны шугам	м	127.3	536,859.90	68,341,503.00	2023.10.02 ГАА-КД-20/2023
2		Ариутгах татуургын шугам	м	163.3	323,889.20	52,891,107.00	
3		15/0.4 кв-ын 100кВа чадалтай иж бүрэн дэд өртөө	ком	1	34,515,230.00	34,515,230.00	
4		15 кв-н цахилгаан дамжуулах кабель шугам	м	1198	167,906.60	201,152,160.00	
Нийт дүн						356,900,000.00	
					(гурван зуун тавин зургаан сая есөн зуун мянга)		